

**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

2023.06.06

Алтай хот

НЭГ:ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эхний хагас жилийн зарцуулалтын үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР:ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

2023 оны эхний хагас жилийн зарцуулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”, аймгийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож, хэрэгжилтийн үнэлгээ хийлээ.

ГУРАВ:ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгон баталсан байна. Аймгийн ОНХС-д 6,177,934.2 мянган төгрөг, сумдын ОНХС-д 6,806,765.1 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилан баталсан байна.

Хүснэгт 1. Зарцуулалт

№	Эх үүсвэр	Батлагдсан төсөв /мян.төг/	Санхүүжүүлсэн дүн /мян.төг/ 2023.05.19-ны байдлаар	Санхүүжилтийн үлдэгдэл /мян.төг/
1	Аймгийн ОНХС	6,177,934.2	1,280,280.5	4,897,653.5

2. Аймгийн ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр 6,177,934.2 мянган төгрөгийн 51 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2023.05.19-ны байдлаар 13 төсөл, арга хэмжээний 970,869.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, 10 төсөл, арга хэмжээний 309,410.9 мянган төгрөгийн санхүүжилтийг гэрээний дагуу олгосон байна. 28 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.

2023 оны 05 дугаар сарын байдлаар бүрэн олгосон санхүүжилт:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	2023 оны эхний хагас жилийн байдлаар олгосон дүн /2023.05.19/	Санхүүжилтийн үлдэгдэл
Үр дүнтэй (100 хувь)						
1	Тайшир сумын "Агро Инноваци сургалт судалгааны төвд зуны хүлэмж нийлүүлэх /шилжих/	"Үнэлэмж Алтай" ХХК	7,594,600	37,973,000	7,594,600	-
2	Газар хагалах анжис нийлүүлэх	"Хансан панзат" ХХК	36,000,000	34,077,000	34,077,000	-
3	ХХААХҮЯ-ны харьяа ХААДС-аас Беларусь улсад үйлдвэрлэсэн трактор, техник, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт (санхүүжилтийн үлдэгдэл)	Хөдөө аж ахуйг дэмжих сан	49,700,000	606,275,100	49,700,000	-
4	Хөргүүртэй 40 тн-ын контейнер нийлүүлэх	"Цацрах мэлмий" ХХК	26,000,000	26,000,000	26,000,000	-
5	Контент бэлтгэх	"Ногоон замын эхлэл" ХХК /Алтай телевиз/	4,698,000	15,660,000	4,698,000	-
6	Сумдад баригдах бага оврын цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зураг төсөлд холболт хийх	"Чанарын түншлэл" ХХК	28,443,200	54,600,000	27,300,000	1,143,200 /Илүү тодотгосон/
Санхүүжилтийг бүрэн олгосон боловч хийсэн ажлын тайлан, гэрээ хүлээн авсан акт, хурлын тэмдэглэлгүй.						
7	Алслагдсан бүсийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийг эцэг, эхийн дэргэд сургах явуулын бүлгийн үйл ажиллагааг дэмжих	БШУГ	19,203,300		19,000,000	203,300

8	Улсын физикийн 34 дүгээр олимпиад зохион байгуулах ажиллагаа үйл	БШУГ	40,000,000		38,000,000	2,000,000
9	Сонгины үр 5 га талбайд тариалах (1 га-ийн норм 500 кг) худалдан авах	ХХААГ	2,500,000		2,500,000	Хийсэн ажлын тайлангүй.
10	Сармисны үр худалдан авах 3 га талбайд тариалах (1 га-ийн норм 550 кг)	ХХААГ	15,000,000		15,000,000	Хийсэн ажлын тайлангүй.
11	Маркетинг, сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээллийн зардал/Хяналтын зардал/	АЗДТГ	15,000,000		15,000,000	Хийсэн ажлын тайлангүй.
12	Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх	ХХААГ	20,000,000		20,000,000	Хийсэн ажлын тайлангүй.
13	Алтай хотын Жанчивын гудамжны тохижилт, шинэчлэлт (Есөнбулаг сум)	Есөнбулаг сумын ЗДТГ	700,000,000	4,740,000,000	700,000,000	Хийсэн ажлын тайлангүй.
Нийт			976,139,100	5,529,585,100	970,869,600	

Хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	2023 оны эхний хагас жилийн байдлаар олгосон дүн /2023.05.19/	Санхүүжилтийн үлдэгдэл
Тодорхой үр дүнд хүрсэн						
1	"Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөр төсөл арга хэмжээний хүрээнд ЕБС, СӨБ-ийн багш, сургууль, хамт олон, менежер, эрхлэгч, захиралд	БШУГ	1,300,000,000	-	71,013,000	1,228,987,000

	урамшуулал олгох, амжилт гаргасан суралцагчдад тэтгэлэг олгох арга хэмжээ					
2	Цахим платформыг хэрэгжүүлэх, ашиглалтын зардал	"Айтүүлс" ХХК	230,000,000	-	1,584,000	228,416,000
3	Бусад арга хэмжээ (Багш нарыг чадавхжуулах, байр, сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ)	БШУГ	45,000,000	-	37,296,500	7,703,500
4	Халиун сумд Хүлэмжийн болон ил талбайн мод үржүүлгийн талбай шинээр байгуулах /шилжих/	"Нутгийн төгөл" ХХК	66,677,490	211,500,000	41,377,860	25,299,630
5	8 байршилд мод усалгааны нөөцийн сав байршуулах	"Хүслэнт хүдэр" ХХК	117,082,919	167,082,919	64,561,887	52,521,032
6	Тэжээлийн ургамал хашаалах тор, шон	"Үнэлэмж Алтай" ХХК	50,000,000	47,177,799	14,153,340	35,846,600
7	Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах, засварлах	"Гранд холдинг" ХХК	72,000,000	70,668,781	22,614,010	49,385,990
8	Заг болон говийн бут, сөөг тариалмалжуулах	БОАЖГ	19,800,000	-	13,860,000	5,940,000
9	Өргөх насос нийлүүлэх	"Хүслэнт хүдэр" ХХК	19,000,000	18,900,000	12,965,400	6,034,600
10	Мал аж ахуй, түүхий эдийг боловсруулж буй гадаадын үйлдвэрүүдтэй танилцах, туршлага судлах арга хэмжээ	Юнайтед бест ойл	45,000,000	-	29,985,000	15,015,000
Нийт			1,964,560,409	515,329,499	309,410,997	1,655,149,412

ДӨРӨВ: ДҮГНЭЛТ

1. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-тэй уялдсан байна.

2. Боловсрол, шинжлэх ухааны газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газарт эрх шилжүүлэн хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн тайлан хангалтгүй, анхан шатны баримтны бүрдэл дутуу байна.

3. Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүнг татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүрэн шивүүлээгүй байна. 3 төсөл, арга хэмжээний 85,561,887 төгрөгийн төлбөрийн баримт л шивэгдсэн байна.

4. Галдан Бошгот хааны онгоны тахилгын арга хэмжээний бэлтгэл хангах зардалд төлөвлөсөн 40,548,987 төгрөг нь Төсвийн тухай хуулийн 60.3 дахь хэсэг “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно” 60.3.3 дахь заалт “үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал”-ыг зөрчсөн байна.

ТАВ: ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст

1. Цаашид эрх шилжүүлэн хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тухай бүр бүрдүүлүүлж авч байх;

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгуулах;

3. Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүнг татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүрэн шивүүлэх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

